



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: 3АА-2026/023/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Улаанбаатар сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-36-12
Цахим ирээдүй: zavkhan@audit.gov.mn

2026.03.20

№

223

талай

-ны №

-т

АЛДАРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА А.МӨНХСАЙХАНД

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алдархаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд татвар болон татварын бус орлого 48,573.4 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 69,646.3 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 57,361.3 мянган төгрөгөөр улсын төсөвт байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгох байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт 14,522.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 93,802.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын гол асуудал

Алдархаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар татварын орлогыг зөрүүтэй тайлагнасан болон хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 60,106.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Алдархаан сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 625,852.8

D:\Албан бичиг\A4-2026.docx

8126050521

мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 709,351.8 мянган төгрөг буюу 113.3 хувьтай байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 58,705.6 мянган төгрөгийг 42 иргэнд буцаан олгожээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		872,438.3	861,891.9
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	536,172.3	430,211.5
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	244,935.1	330,480.3
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	91,330.8	101,200.1
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,518,086.9	6,764,617.1
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,518,086.9	6,764,617.1
7	1.2.2.02 Биет хөрөнгө		1,429,609.8	6,676,377.5
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	88,477.1	88,239.6
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		2,390,525.2	7,626,509
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		138,547.2	177,858.8
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		138,547.2	177,858.8
12	2.1.1.03 Өглөг		138,547.2	177,858.8
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,251,977.9	7,448,650.1
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		2,251,977.9	7,448,650.1
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		449,344.4	449,344.4
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		1,737,875.8	6,934,548
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		64,757.7	64,757.7
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		2,390,525.2	7,626,509

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,436,166.2	7,390,760.5
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		631,381.2	615,704.7
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		425,231.8	342,595.3
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		452,612.7	401,300.9
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-27,380.9	-58,705.6
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		113,598.8	129,538.5
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		92,550.7	143,570.9
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	777,329.2	6,775,055.8
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	748,886.9
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,027,455.8	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,616,007.2	1,732,052.7
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,616,007.2	1,732,052.7
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,477,830	1,704,037.3
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		576,639.1	708,135.7
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		88,725.2	93,201.6
16	1.1.2 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		443,729.7	387,696.8
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		56,752.1	89,039.1
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		10,629.7	17,264.5
19	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		3,950.1	5,442
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,825.6	3,171.8
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		289,578.6	400,085.9
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		138,177.2	28,015.4
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		820,158.9	5,658,707.8
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		352,627.5	481,630.7
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-352,627.5	-481,630.7
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		467,531.4	5,177,077.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,784,446.5	1,784,446.5
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,784,446.5	1,784,446.5
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	467,531.4	467,531.4
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,251,977.9	2,251,977.9
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,251,977.9	2,251,977.9
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	19,595.1	19,595.1
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,271,573	2,271,573
8	1.7 Тайлант үеийн үр дүн	5,177,077.1	5,177,077.1
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,448,650.1	7,448,650.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	1.1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,745,880.8	1,797,218.7
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	631,381.2	615,704.7
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	425,231.8	342,595.3
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-27,380.9	-58,705.6
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	113,598.8	129,538.5
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	92,550.7	143,570.9
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,918.9	9,338.3
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	50,559.6	59,587.8
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	39,072.3	74,644.8
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,043.8	1,181,514
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	87,043.8	88,783.8
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	759,846.9
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	332,883.3
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,027,455.8	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,364,923	1,478,790.4
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,364,923	1,478,790.4
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,226,745.8	1,450,775
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,118.4	718,045.7
19	1.1.1.2.01 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,030.8	94,803.8
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	320,014.3	340,163.8
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	37,142.6	38,878.4
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	13,730.6	35,551
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	3,950.1	5,442
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,272.2	3,662.2
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	185,486.8	214,227.9
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,177.2	28,015.4
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)	380,957.8	318,428.4
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	412,411.1	374,239.2
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	412,411.1	374,239.2
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	412,411.1	374,239.2
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-412,411.1	-374,239.2
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,150	50,150
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100,150	-50,150
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-131,603.3	-105,960.9
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	667,775.7	536,172.3
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	536,172.3	430,211.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,226,388.60	1,897,707.78
11	3.1.01.1.1 Татварын орлого	622,852.80	615,704.75
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	438,756.80	342,595.35
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	468,137.70	401,300.94
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	341,116.30	322,516.01
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	9,000.00	42,825.12
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	86,200.00	-
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	3,000.00	665.66
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	28,821.40	35,294.14
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(29,380.90)	(58,705.59)
110101	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(29,380.90)	(58,705.59)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	104,040.00	129,538.49
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	72,000.00	93,533.17
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	2,440.00	545.00
113003	3.1.01.1.1.3.3 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	-	5,917.29
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	29,600.00	29,543.03
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	80,056.00	143,570.91
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,450.00	9,338.33
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	1,450.00	1,556.93
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,500.00	5,302.40
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,500.00	2,479.00
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	30,806.00	59,587.82
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	30,806.00	32,948.06
118102	3.1.01.1.1.8.2.02 Дуудлага худалдаа	-	26,639.76
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	43,800.00	74,644.76
118201	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	5,800.00	1,870.39
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	35,000.00	52,652.00
118203	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2,500.00	19,920.95
118204	3.1.01.1.1.8.3.04 Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	500.00	201.42
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,603,535.80	1,282,003.04
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	143,291.30	83,583.82
120002	3.1.01.1.2.1.2 Хүүгийн орлого	-	14,837.14
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	3,000.00	19,904.36
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого	140,291.30	48,642.32
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	-	200.00
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,137,361.20	865,535.90
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	363,294.00	363,294.00
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	774,067.20	502,241.90
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	322,883.30	332,883.32
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	322,883.30	332,883.32
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,226,388.60	1,795,049.59
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,531,910.20	1,421,940.38
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,508,837.30	1,407,477.48
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	762,799.00	718,045.66
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	506,074.00	418,736.82
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	172,181.70	207,568.58
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	73,991.70	37,855.78
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	10,551.60	53,884.49

2102	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,350.10	94,803.80
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	65,211.30	64,801.90
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	7,534.70	7,490.90
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	3,767.40	3,783.40
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	3,767.40	3,745.60
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	15,069.30	14,982.00
2103	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,080.60	340,163.84
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	27,864.90	41,331.87
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	300,101.50	297,326.28
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	5,114.20	1,505.69
2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	40,009.30	37,818.88
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	5,948.30	6,674.60
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шагахуун	26,338.40	24,628.25
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,457.60	3,614.13
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,265.00	2,901.90
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	87,091.80	86,732.65
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	74,892.80	51,281.60
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	12,199.00	35,451.05
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	5,449.10	5,442.00
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	5,449.10	5,442.00
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,274.00	2,706.10
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900.00	1,640.00
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	469.10	-
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	827.70	336.70
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношилгоо	873.80	640.40
210806	3.1.01.2.1.1.8.0	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	89.00
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	180,783.40	121,764.55
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	178,733.40	120,297.75
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,050.00	1,466.80
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,072.90	14,462.90
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	23,072.90	14,462.90
213204	3.1.01.2.1.4.2.03	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,890.00	3,630.00
213207	3.1.01.2.1.4.2.06	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,332.90	10,332.90
213209	3.1.01.2.1.4.2	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,850.00	500.00
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	530,329.40	322,959.21
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	530,329.40	322,959.21
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	164,149.00	50,150.00
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	164,149.00	50,150.00
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(914,358.50)	(107,410.86)
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	914,358.50	107,410.86
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	914,358.50	107,410.86
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	529,072.34
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	421,661.48
6	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	46.00	46.00
61	6.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	6.1.01	Төсвийн байгууллага	2.00	2.00
62	6.2	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00
620001	6.2.01	Удирдах ажилтан	11.00	10.00
620002	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	9.00	10.00
620003	6.2.03	Үйлчлэх ажилтан	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	102,460,052.70
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,460,052.70
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	102,460,052.70
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	102,460,052.70
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	102,460,052.70
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	102,460,052.70
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,827,477.70
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	90,827,477.70
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,827,477.70
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,157,965.20
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	1,157,965.20
2108	1.1.1.2.1 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	956,112.50
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	956,112.50
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	88,713,400.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	88,713,400.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	11,632,575.00
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(11,632,575.00)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(11,632,575.00)

Гурав. Аудитын илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 60,109.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3 заалт зөвлөмж өгсөн.

Аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Залруулгын алдаа: Аудитаар залруулга хийгдээгүй болно.

3.2 Төлбөрийн акт: Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

3.3 Албан шаардлага: Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй болно.

3.4 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

Илрүүлэлт: Харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 60,106.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.3-д “энэ журмын 3.4.2-т заасан төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэнтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих”, 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг холбогдох хууль, журмын дагуу бодитой хэрэгжүүлж, хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллах;

2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой

Илрүүлэлт: Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлээгүй, 5 нэр төрлийн орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1. "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах;

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлсэн байдлын хэрэгжилт 74.2 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 88.1 хувьтай, мэдээлэл зохих 181 мэдээллээс 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.1.6-д "төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт", 2.2.1.13-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох шийдвэрийн хуулбарын хамт", 2.2.2.1-д "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө", 2.2.2.2-д "худалдан авах ажиллагааны тайлан", 2.2.3.2-т "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 3.2-д "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ", 3.2.1-д "худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар", 3.2.10-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд төсөв санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших, 6.1.1 дэх хэсэгт байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайланг, 6.1.5 дахь хэсэгт аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг", 6.4.5 дахь хэсэгт цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлж байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу-лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алдархаан сумын ЗДТГ	4	246,980.5	1	19,000.0	3	227,980.5	4	246,980.5				
Алдархаан сумын ИТХ												
Алдархаан сумын ОНХС												
Алдархаан сумын ХХС												
Алдархаан сумын Засаг дарга												
Дүн	4	246,980.5	1	19,000.0	3	227,980.5	4	246,980.5				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Алдархаан сумын ЗДТГ	4	32,364.3	1	2,138.4	2	12,850.0	1	17,375.9				
Алдархаан сумын ИТХ	1	88,451.1			1	88,451.1						
Алдархаан сумын ОНХС	5	19,632.9			5	19,632.9						
Алдархаан сумын Засаг дарга	2	60,109.3					2	60,109.3				
Дүн	12	200,557.6	1	2,138.4	8	120,934.0	3	77,485.2	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										

/мянган төгрөгөөр/

Алдархаан сумын ЗДТГ	1	2,955,483.8				1	2,955,483.8		
Алдархаан сумын Засаг дарга	1	-				1	-		
Дүн	2	2,955,483.8				2	2,955,483.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Алдархаан сумын ХХС	1	88,451.1				1	88,451.1		
Дүн	1	88,451.1				1	88,451.1		
Нийт дүн	3	3,043,934.9				1	88,451.1	2	2,955,483.8

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	4	1	3		1				
2	ТТЗ	1	1				1			
	НИЙТ	5	2	3		1	1			

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

Ц.ОЮУНСУВД

Огноо: 2026-03/25

Огноо: 2026-03-25